

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны
98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ АЖИЛТАН Ж.САНДУЙЖАВЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. “АЙМГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОГДСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” зорилтын хүрээнд:							
1.1	Гадны ЭСЯ болон хөтөлбөрийн газруудтай холбоотой ажиллаж, төслийн мэдээллээр аймаг орон нутгаа хангах	Санал, мэдээлэл харилцан солилц-сон, удирдлага мэдээллээр хангагдсан байх	100	Хэрэгжилт 90-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	Эхний хагас жилд Унгар, АНУ, ОХУ, Солонгос улсын Элчин сайд нар болон ЭСЯ-ны газар, хэлтсийн ажилтнууд Орхон аймагт ажилллав: - Шинээр барьж ашиглалтад авсан Номын өргөөнд АНУ-ын ЭСЯ-тай хамтран “Америкийн соёл мэдээллийн төв” байгуулах ажлаар 3 удаа хамтран ажиллаж, тус төвийн үйл ажиллагаа жигдрээд байна. - Унгар улсын Элчин сайд Орхон аймагт ажиллаж удирдлагуудтай уулзан санал солилцсоны дээр, Унгарт англи хэлээр сурч боловсрол эзэмших асуудлаар ЕБС-ийн сурагчдад мэдээлэл өглөө. Мөн яруу найрагч Ш.Петэфигийн нэрэмжит уран уншлагад шалгарсан сурагчдыг урамшуулсан. - Япон улсын Элчин сайд “Инновацийн долоо хоног” нэгдсэн арга хэмжээнд оролцож мэндчилгээ дэвшүүлсэн. Энэ үеэр аймгийн Засаг дарга Элчин сайдыг хүлээн авч уулзан Япон оронтой хэрхэн хамтран ажиллаж ирсэн болон одоо Токамачи хоттой ямар түвшинд харилцаж байгаа талаар мэдээлэл өгөв.	2024.01.02 2024.12.31	

					Tус улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хөтөлбөрийн газартай тогтмол мэдээлэл солилцож, өрсдийн хэрэгцээ шаардлагаа илэрхийлсэн 5 төслийг хүргүүлсэнээс БОЭТ-ийн төсөл эцсийн шатны хуралдаан орохоор шалгарсан. -Солонгос улсын Элчин сайд Эрдэнэт үйлдвэрээс зохион байгуулсан "Уул уурхайн ассоциацийн хөгжлийн төлөв байдал"-ын зөвлөгөөнд оролцоход нь аймгийн удирдлага хүлээн авсан. -ОХУ-ын Элчин сайд "Эрдэнэтийн өдрүүд"-ийн арга хэмжээнд оролцож, аймгийн удирдлагууд хүндэтгэл үзүүлэн хүлээн авсан. Илгээлтийн ээдийн бүтээн байгуулалтын 50 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд ОХУ-ын Худалдааны төлөөлөгчийн газрын тэргүүн А.Васильев тэргүүтэй төлөөлөгчид ирж оролцов. -Монгол-Оросын найрамдал хамтын ажиллагааны өдрүүд, Эх орны дайны ялалтын өдөр зэрэг арга хэмжээнд 8 сая төг захирамжаар зарцуулж, Ерөнхий Консулын газар, Эрдэнэт үйлдвэртэй хамтран ажилласан. -Япон, АНУ, Унгар, Герман улсын ЭСЯ-дад хандаж, виз авах шаардлагатай удирдах ажилтнуудын цаг, мэдүүлэг зэргийг бүрдүүлэн хүргүүлсэн байна. -	
1.2	Гадаадын хот, мужуудтай цар тахлаас үүдэн тасалдсан харилцааг сэргээн хөгжүүлэх, шинээр гадаадын 1-2 хот, мужтай харилцан ашигтай хамтын ажиллагаа тогтоох	Харилцаа холбоо тогтоох хот, мужтай холбогдож, албан тоот солилц-сон, харилцан ойлголцолд хүрсэн байх	100	Аймгийн удирдлагууд мэдээллээр цаг тухай бүр хангагдаж, 1-2 хоттой шинээр найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай болсон байна.	БНХАУ-ын Ухань хотын удирдлагуудыг хүлээн авах Санамж бичиг үзэглэхтэй холбоотой асуудлыг зохион байгуулж ГХЯ, аймгийн удирдлагуудтай хамтран ажиллав. Солонгос улсын Дэгү хоттой Эрүүл мэнд, биеийн тамир, барилгын салбарт хамтран ажиллахаар айлчлалын үеэр Санамж бичиг үйлдэж ажилласан. -Солонгос улсын Сунчон мужийн Боловсролын салбарын төлөөлөгчдийг Орхон аймагт 6-р сард хүлээн авч уулзалт зохион байгуулж, Санамж бичиг үйлдсэн бөгөөд 9-р сард Засаг даргын	2024.01.02 2024.12.31

					орлогч тэргүүтэй манай аймгийн төлөөлөгчид Сунчон хотод айлчилсан. Вьетнам улсын Даклак муж, Японы Токамачи хот, ОХУ-ын Улаан-Үд хотын удирдлагуудыг Үндэсний их баяр наадам, Илгээлтийн эздийн бүтээн байгуулалтын 50 жилийн ойд хүндэт зочноор оролцулсан.		
1.3	Аймгийн удирдлагууд болон төрийн байгууллагуудын төлөөлөгчдийн албан айлчлалд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, гадны зочдыг хүлээн авах бэлтгэл ажил хангаж, ёслолын арга хэмжээ зохион байгуулах	Аймгийн удирдлага болон гадны үйлчлүүлэгчдээс санал гомдол гарцаагүй байх	100	Хэрэгжилт 90-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	<p>Аймгийн Засаг дарга М.Түмэнжаргалын Солонгос, Япон улсуудад хийсэн айлчлалын бэлтгэлийг хангаж, тулгамдсан асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэн захирамж гаргуулан ажилласан. Япон улсын ЭСЯ, Токамачи хотын захирагаа, "Монгол анд нөхдийн холбоотой нягт уялдаатайгаар айлчлалыг амжилттай зохион байгуулав. Ялангуяа Японы талаас хүлээн авах аялалын болон албан уулзалтуудын хөтөлбөрийг гардан боловсруулж, айлчлалын бүрэлдхүүнд орж ажиллав.</p> <p>-Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Ганзориг тэргүүтэй төлөөлөгчид Улаан-Үд хотын баярын үйл ажиллагаанд оролцоход зохион байгуултаар хангаж ажиллалаа.</p> <p>-Аймгийн боловсрол, Соёл, ХХАА-н салбарын ажилтны төлөөлөгчид ОХУ-ын Буриадын холбогдох салбаруудын үйл ажиллагаа, туршлага судлах аялалыг 10-11-р саруудад зохион байгуулсан.</p> <p>-Буриадын Драмын театрын тогтолт болон Соёлын сайд С.Дагаевагийн айлчлалыг Орхон аймагт зохион байгуулав.</p> <p>-Буриад түмний "Алтаргана наадмыг зохион байгуулах ажиллагаанд Буриадын төлөөлөгчдөд дэмжлэг үзүүлэн ажиллах үүрэг гүйцэтгэсэн.</p> <p>-Тайлант 2024 онд 5 орны ЭСЯ-ны удирдлага, гадны зочдыг хүлээн авах ажиллагааг "Амарын танхим"-д зохион байгуулан хөтөлж явуулсан.</p>	2024.01.02 2024.12.31	

1.4	Бие даан болон бусад агентлаг байгууллагатай хамтран 1-2 төсөл бичиж удирдлагад танилцуулах	Төсөл удирдлагын түвшинд танилцуулагдаж, дэмжигдсэн байх	100	Хэрэгжилт 90-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	<p>ХХААГ болон Фермерийн аж ахуй эрхлэгчдийн хүсэлтийг Буриадын Засгийн газрын тэргүүнд уламжилж, бус нутгийн хүрээнд эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэхэд хамтран ажиллах санал тавьсан.</p> <p>ОХУ-ын Эрхүү хотын Техникийн их сургуулийн 26 хүний бүрэлдхүүнтэй ажлын хэсгийг хүлээн авч аймгийн ЕБС-ийн төгсөх ангийнхан, Их дээд сургуулийн нэгдүгээр курсын оюутнууд Технологийн сургуулийн хамт олонтой уулзуулж, хамтран ажиллах боломжийн талаар үр дүнтэй яриа хэлцэл хийсэн. Хамтарсан олимпиад зохион байгуулж, шалгарсан 4 сургачийг тус сургуульд тэтгэлэгээр суралцсан эрх олгожээ.</p> <p>Аймгийн Хот тохижуулах газарт шаардлагатай цас хайлзуулах бодис, материалын талаархи мэдээллийг ОХУ-ын зах зээлээс хэрхэн олж болох мэдээллийг тус газарт гаргаж өгөв.</p> <p>-Япон улсад суугаа Монгол улсын ЭСЯ-нд Орхон аймагт хэрэгцээтэй байгаа зарим техник төхөөрөмж, эд хогшлын судалгааг гарган хүргүүлэв.</p> <p>-Унгар улсын ЭСЯ-наас Европын холбооны ЭКСИМ банкаар дамжуулан 3 төслийг танилцуулахаар болов.</p>	2024.01.02 2024.12.31	
1.5	Аймгийн инноваци бүтээмжийн зөвлөлийн үйл ажиллагаанд санал өгөх эрхтэйгээр оролцох	Зөвлөлийн гишүүн байх	100	Хэрэгжилт 90-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	<p>Инноваци бүтээмж, шилдэг төсөл шалгаруулах 2023 оны шалгаруулалтад шалгарсан хамт олны санхүүгийн баримтыг бүрдүүлж ажиллав.</p> <p>Тодорхой төслүүдийг дэмжих асуудлаар зевлөл тайлант онд 3 удаа хуралдсан.</p> <p>2024 оны 5-р сард БШУ-ны Яамтай хамтран “Инновацийн долоо хоног” арга хэмжээ Орхон аймагт тусгай хөтөлбөрийн дагуу явагдлаа. Тус арга хэмжээнд Орхон аймгаас 20 сая төгийн дэмжлэг үзүүлсэнийг захирамжлав. Миний хувьд сургалтын танхим бэлтгэх, Японы Элчин сайдад үйлчлэх зэрэг ажлыг хариуцан ажиллалаа.</p>	2024.01.02 2024.12.31	

1.6	Инноваци , бүтээмж шингэсэн төслүүдийг шалгаруулах замаар дэмжлэг үзүүлж ажиллах	Шалгаруулалт явагдаж, төслүүд санхүүгийн дэмжлэг авсан байх	100	Хэрэгжилт 90-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	"Инновацийн долоо хоног" арга хэмжээний үеэр танилцуулагдсан хот орон нутгийн 20 гаруй байгууллага, эрдэмтдээс сонирхол татахуйц теслийн танилцуулга хийгдсэнийг аймгийн зөвлөл, ШУТП-ын хүрээнд авч үлдсэн байгаа. Цаашид орон нутгаас дэмжин хэрэгжүүлж болох төслүүдээ Засаг даргын зөвлөл, ИТХ-д танилцуулах чиглэлээр ажиллаж байна.	2024.01.02 2024.12.31		
ХОЁР. "ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:								
2.1	1 Хэлтсийн хариуцах чиглэлээр эрх бүхий гадаад дотоодын байгууллага, албан тушаалтан, иргээс шийдвэр гаргуулахаар болон дэмжлэг хүсэж тавьсан асуудлыг судалж шийдвэрлүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах	Үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан байна.	100	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 50-аас доошгүй хувь биелүүлэн ажилласан байна.	Aймгийн төлөөлөгчдийн айлчлал, гадны зочдыг хүлээн авах төсөв зардлыг Сангийн сайдын 2011 оны 188-р тушаал болон аймгийн ИТХ-аас тухайн оны төсөв зардлыг зүйлчлэн баталсан тогтоолын хүрээнд төлөвлөн зарцуулдаг. Захирамж төлөвлөн батлуулах журмын хүрээнд хянагдж шийдвэр болж гардаг. Гадны орны ЭСЯ-д болон олон улсын байгууллагаас төлөөлөгчид айлчлан ирсэн тохиолдолд уулзалтын тэмдэглэлийн нэг хувийг үүргийн дагуу Тагнуулын байгууллагад өгч ажиллаж байна. Үүргийн дагуу аймгийн ИТХ болон Засаг даргын 4 удаагийн айлчлалын үед ГХЯ-ны холбогдох газар, мэргэжилтнүүдээр дамжуулан зөвшөөрөл, ярианы сэдэв авч ажиллав.	2024.01.02 2024.12.31		
2.2	2.2 Олон нийтэд тустай мэдээллийг гадаад хэл, мэдээллийн давуу эх сурвалжаас олж нийтийн хүртээл болгох		100	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 50-аас доошгүй хувь биелүүлэн ажилласан байна.	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийтийн сүлжээгээр Гадаад орны Их дээд сургуулиудад бүрэн болон хувь тогтоосон тэтгэлэгээр суралцах боломж, бүрдүүлэх материалтай холбоотой мэдээллийг 150 гаран удаа түгээж ажиллалаа. Үүнд ОХУ, АНУ, БНХАУ, Австрали, Англи, Унгар, Чех, Болгар, Турк, Франц, Япон, Итали, Солонгос зэрэг орны сургуулиудын мэдээлэл, холбогдох хаяг, албан тушаалтны мэдээллүүд багтсан болно.	2024.01.02 2024.12.31		

ЗОРИЛТ 3. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ зорилтын хүрээнд:

Д/Д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	3.1 ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, холбогдох албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	100	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн байна.	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Таван жилийн үндсэн чиглэл, Тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулан Хэлтсийн даргаар хянуулан батлуулж, хэрэгжилтийг хангтан ажиллаж байна. Ж.Сандуйжав миний Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь нийт 3 зорилт хэрэгжүүлэх 13 арга хэмжээнээс бүрдэж байна. Хугацаанд нь тайлагнан ажиллав.	2024.01.02 2024.12.31	
2.	3.2 “Архив, албан хэрэг хөтлөлт” тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангтан ажилласан байна.	100	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангтан ажиллана.	Архив, бичиг хэрэгт холбогдох материалуудыг хулээлгэн өгсөн Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг мөрдөн зөрчил гаргаагүй болно.	2024.01.02 2024.12.31	
3	3.4 Удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.	Удирдлагын зүгээс гомдол гаргаагүй байх	100	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг чиг үүргийн болон чиг үүргийн бус гэсэн ялгамжгүйгээр	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг чиг үүргийн болон чиг үүргийн бус гэсэн ялгамжгүйгээр	2024.01.02 2024.12.31	

54

					<p>цаг хугацаанд нь гомдол чирэгдэлгүй биелүүлэхийг хичээж ажиллав. Чиг үүргийн бус үүрэг даалгавар нь:</p> <p>-Аймгийн Засаг даргаар ажиллаж байсан Д.Оюунбат, Д.Чагнаадорж нарт эмчилгээний тэтгэмж олгуулах талаар санал танилцуулсан.</p> <p>- Ерөнхий сайд агсан А.Амарын хөшөөг сэргээн засварлах аж ахуйн нэгж – Автын кузов засварын газрыг олж Тамгын газрын даргад санал болгосон.</p> <p>-Халх голын байлдааны ялалтын 85 жилийн ойд зориулсан ахмадуудын аялалыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.</p> <p>-ОХУ-ын Боловсролын бичиг баримт баталгаажуулалтын газар болон Эрхүү хот руу Орхон аймгийн иргэн Г.Пүрэвсүрэн, Б.Эрдэнэбаатар нарын Их, дээд сургууль төгссөн дипломыг баталгаажуулах хүсэлт илгээн хариуг буцаан авч хүсэлт гаргасан иргэдэд хүлээлгэн өгсөн.</p> <p>Байгууллагаас баталсан хөдөлмөрийн дотоод журам, албан хаагчдын ёс зүйн дүрэм болон үйлчилгээний стандарт, ТАХ-ийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--	---	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1.							
1.	Шинээр батлагдсан хууль тогтоомжийг судалж, үйл ажиллагаандаа ашиглах.	Хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулсан байна.			"Алсын хараа-2050" сургалтад хамрагдан гэрчилгээ авсан. Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн үйлчлэлээр орж ирэх бараа үйлчилгээг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх журмыг сурталчилсан онлайн сургалтад хамрагдан олж авсан мэдээллээ удирдлага, зарим ажилтнуудад мэдээлсэн. Сангийн сайдын Гадаад томилолтыг зохицуулах журамд өөрчлөлт орсоныг ажилдаа мөрдөн ажиллаж байна.	2024.01.02 2024.12.31	
2.	Хуучин монгол бичгийн чадвараа дээшлүүлэх	Чадвар ахисан байна.			Огт мэддэггүй байсан бол үсэг тогтоож, үсэглэн уншдаг болж байна.	2024.01.02 2024.12.31	

ТАЙЛАН ГАРГАСАН: Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Инноваци, бүтээмж, төсөл хөтөлбөр хариуцсан ахлах ажилтан

Ж.САНДУЙЖАВ

2024.11.29